


МОНГОЛ УЛС
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

**МОН 3948: “БҮС НУТГИЙН
ХӨГЖЛИЙН НЭГДСЭН
ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧАДАВХИЙГ
БҮРДҮҮЛЭХ НЬ”
ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА**

**БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖИЙН
БАРИМТ БИЧИГ №6 :
ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ ЗАХ
ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН
ТОГТОЛЦООНД**

2004 ОНЫ 3-Р САР

БОЛОВСРУУЛСАН



ПДП АВСТРАЛИЙН КОМПАНИ

ГАРЧИГ

Өмнөх үг.....	1
Бодлогын зөвлөмжийн баримт бичгийн жагсаалт.....	1
Бүс нутгийн бодлого	
Баримт бичгээс гарах үндсэн зөвлөмжүүд.....	3
Бүс нутгийн хөгжил: Засгийн газрын үүрэг зах эзлийн эдийн засгийн тогтолцоонд	3
1. Оршил.....	4
1.1 Төвлөрөл ба төлөвлөлт	4
1.2 Зохион байгуулалт, онолын сүүлийн үеийн асуудлууд	5
1.3 Хотжилт.....	6
1.4 Тогвортой оршин тогтох	7
2. Зах зээлийн эдийн засаг	9
2.1 Зах зээлийн эдийн засгийн тодорхойлолт.....	9
2.2 Зах зээлийн алдаа	9
2.3 Өрсөлдөх давуу тал	11
3. Засгийн газрын үүрэг бүс нутгийн хөгжилд.....	12
3.1 Засгийн газрын ерөнхий үүрэг.....	12
3.2 Засгийн газрын үүрэг бүс нутгийн хөгжилд	12
Ном зүй	19

ӨМНӨХ ҮГ

Энэ нь МУ-ын БНХ-ийн бодлого, төлөвлөлтийн тодорхой асуудлыг авч үзэж байгаа цуврал баримт бичгийн зургаадугаарх нь юм. “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ-ны хүрээнд хийгдсэн ажлын явцад анхаарал татсан сэдвүүдийг сонгон авсан болно. Зарим сэдвүүд нь төрийн албан хаагчдын дэвшүүлж байсан асуудал, хүсэлттэй холбоотой.

Эдгээр баримт бичгүүд нь товч бөгөөд ЗГ, олон улсын хөгжлийн байгууллага зэрэг холбогдох бусад талуудад бодлогын хэлэлцүүлгийн асуудлаар мэдээлэл өгөх, түүнчлэн ЗГ, төрийн байгууллагын БНХ-ийн бодлогын чадавхийг бэхжүүлэхэд тус дэм болох юм. Баримт бичигт хэлэлцсэн асуудлаар онцлог зөвлөмжүүдийг боловсруулж тусгасан болно.

Монгол улс болон түүний ард түмний цэвэр эрх ашгийн төлөө мөн үү? Өөрөөр хэлбэл хэлэлцэж буй асуудлаар дэвшүүлсэн санал, стратеги нь нийгэм/эдийн засгийн үр ашигтай юу? гэсэн зарчмын асуултад бүх баримт бичгүүд тулгуурласан болно. Түүнчлэн хэлэлцэж буй зарим асуудлыг шийдвэрлэх илүү үр дүнтэй өөр арга зам байна уу? гэдгийг мөн харгалзан үзсэн юм.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖИЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

- № 1: Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах “үйл явц”-д тулгуурлах арга зам. 2003 он, 12 сар (англи, монгол).
- №2: Бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн онол, тодорхойлолтууд. 2003 он, 12 сар (англи, монгол).
- № 3: Монголын бүс нутгийн хөгжлийн үзүүлэлтүүд ба индексүүд, 2004 оны 1 сар (англи, монгол).
- № 4: Функциональ бүс нутгуудыг тодорхойлох нь, 2004 оны 2 сар (англи, монгол).
- № 5: Тулгуур төвүүд, үйлдвэр, аж ахуйн газрын кластер ба бүс нутгийн хөгжил (англи, монгол).
- № 6: Бүс нутгийн хөгжил: засгийн газрын үүрэг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд (англи, монгол).
- №. 7: Бүс нутгийн хөгжлийн удирдлага, бүтэц зохион байгуулалтын асуудлууд (англи, монгол)

БҮС НУТГИЙН БОДЛОГО

Бүс нутгийн бодлого нь:

- 1 Тухайн улс орны бүс нутгууд, ялангуяа нийслэл хот, түүнээс алслагдсан бүс нутгууд хоорондын тэнцвэрт бус байдлыг багасгах арга хэмжээ юм.
- 2 Онц хүндрэлтэй нөхцөлд байгаа хот, хотхон, бусад харьцангуй жижиг суурин газруудад ЗГ-аас үзүүлэх тусламж дэмжлэг юм. (Роутледж Эдийн засгийн толь бичиг, 2002)

БАРИМТ БИЧГЭЭС ГАРАХ ҮНДСЭН ЗӨВЛӨМЖҮҮД

Зах зээлийн эдийн засагт ЗГ хэд хэдэн үндсэн үүрэг функцтэй байдгийг бүх нийтээр хүлээн зөвшөөрдөг. Бүс нутгийн хөгжилтэй холбогдуулвал эдгээр нь макро, микро бодлогуудыг тодорхойлох, хувийн салбарын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж, таатай орчныг бүрдүүлэх бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх, нийгмийн үйлчилгээтэй гол төлөв холбоотой зах зээлийн алдааг залруулах, ил тод байдлаар шаардлагатай хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлэх, бодлого, төлөвлөлтийн зохицуулалтыг хийх юм.

Иймд, бүс нутгийг яаж хөгжүүлэх талаар дээрээс зааварчлахгүй харин бүс нутгийн хөгжлийг дэмжих, хөнгөвчлөх, зохицуулах, түүнчлэн зах зээлийн алдааг залруулах гэсэн үндсэн үүрэгтээ анхаарахыг **зөвлөмж** болгож байна.

Зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмууд, ЗГ-ын хүлээх үндсэн үүрэг зэргийг харгалзан БХҮБ, БХДХС-ийг дахин авч үзэхийг **зөвлөмж** болгож байна.

Бүс нутгийн бодлого, төлөвлөлтийг хийхдээ олон нийтийн санаа бодлыг тусгах зориулалттай “доороос дээш чиглэсэн” аргыг хэрэглэхийг **зөвлөмж** болгож байна.

Монгол улсын ЗГ-т микро эдийн засгийн бодлогыг боловсруулах чадавхи дутмаг байна. Энэ хүрээг бэхжүүлэх зорилгоор хандивлагчдын тусламж дэмжлэгийг авахыг **зөвлөмж** болгож байна. СЭЗЯ-ны Эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн газарт нь энэ дэмжлэг тусалцаа илүү шаардлагатай болов уу.

ҮХ, БЗ-үүдийн дэргэд байгуулагдах мэргэжлийн албууд нь бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааг зохицуулах үүргийг хүлээж харин салбарын яамдууд удирдан хэрэгжүүлэх үүргийг хүлээх хэвээр байхыг **зөвлөмж** болгож байна.

Бүс нутгийн хөгжлийг зохицуулах, ҮХ-д мэргэжлийн зөвлөлгөө, тусламж үзүүлэх үүрэг бүхий чадварлаг бүрэлдэхүүнтэй мэргэжлийн албыг ХЭГ-т байгуулахыг **зөвлөмж** болгож байна.

Энэхүү мэргэжлийн албыг байгуулах, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд АХБ-аас тусламж дэмжлэг үзүүлэхийг **зөвлөмж** болгож байна.

Дэмжлэг, тусалцааг хаана, ямар чиглэлээр үзүүлэх талаар гарч байгаа зөвлөмжүүдийг үндэслэн АХБ дэмжлэг тусалцааг чиглүүлэхийг **зөвлөмж** болгож байна.

БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ: ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТОЛЦООНД

1. ОРШИЛ¹

1.1 Төвлөрөл ба төлөвлөлт

Дэлхийн хоёрдугаар дайны дараах үед бүс нутгийн хөгжлийн бүтэц зохион байгуулалт, төлөвлөлт нилээд төвлөрсөн загвараар хөгжиж ирсэн. Төвлөрсөн төлөвлөлтийн нэг үндсэн зарчмыг “нэгдсэн оновчтой байдал” гэж Коста (1998, х.2) тодорхойлсон байдаг. Үүнд:

“Төвийн нэгж нь эдийн засаг, нийгмийн нөхцөл, байдал болон бусад нийгмийг бүрдүүлэгч хэсгүүдийг хамарсан улс үндэстний амьдралын ахуй нөхцөл, байдлын талаар өргөн хүрээтэй мэдлэг авах боломжтой гэдэгт энэ арга тулгуурладаг. Нэгэнт эдгээр мэдлэгийг олж авсан нь төвийн нэгж оновчтой шийдвэрийг гаргах суурь болж өгдөг, учир нь энэхүү төвийн нэгж нь эдгээр мэдлэгийг эзэмшиж байгаагийн хувьд үндэстний [бүс нутгийн] эдийн засгийг хэрхэн цааш хөгжүүлэх талаар хамгийн сайн мэдлэгтэй байх юм.”

Иймд, төвлөрсөн төлөвлөлтийн үед орон нутаг, бүс нутгийн төлөвлөлтийн санаачлага, арга хэмжээ нь “дээрээс доош” чиглэсэн байдаг; энэ аргыг БХҮБ, БХДХС зэрэг баримт бичгүүдэд хэрэглэсэн байна. АХБ-ны анхны баримт бичигт дурьдснаар, “БХҮБ нь зах зээлийн эдийн засгийг дэмжихийг зорьсон хэдий ч төвлөрсөн төлөвлөгөөний аргад тулгуурлж байгаа бөгөөд дэд бүтцийн бодит, биет төлөвлөлтийн загварыг түлхүү анхаарч, эдийн засаг нийгмийн хөгжилд үзүүлэх үр дүнгийн талаар чухал чухал үнэлгээ, дүн шинжилгээг бага хийж байгаа нь үүний тод жишээ юм.” Монголын засгийн газрын бодлого боловсруулах, стратегиар төлөвлөх чадвар бүхий боловсон хүчин дутагдалтай, түүнчлэн зах зээлийн эдийн засгийн зарчмын зохистой

¹ This first section draws substantially on Costa, Noble, Dutt and Kent (1998).

мэдлэг сул байгаагаас голлон шалтгаалж байгаа бөгөөд энэ нь зах зээлийн эдийн засгийн жамаар хөгжих гэж байгаа Монгол орны чадавхийг их хэмжээгээр хязгаарлаж байна”.

ТТ-ны хүрээнд хийсэн ажлын үр дүн дээрх дүгнэлт хэвээр байгааг харуулж, БХҮБ, ДХБХС-ийг дахин авч үзэх, боловсронгуй болгох гол зөвлөмжийг гаргасан (Бодлогын зөвлөмжийн баримт бичиг №4: Функциональ бүс нутгуудыг тодорхойлох нь”).

1.2 Зохион байгуулалт, онолын сүүлийн үеийн асуудлууд

Бүс нутгийг хөгжүүлэх төвлөрсөн, “дээрээс доош” чиглэсэн аргыг өнөөгийн орчин үед дэмжидгүй. Иймд төлөвлөлтийн онол, практикт “нэгдсэн оновчтой байдал” гэсэн санаанаас “улс төрийн жижиг хамт олон”, орон нутгийн асуудлыг орон нутагтаа оролцооны аргаар шийдэх, ардчилсан засаглал гэсэн ойлголт руу нилээд хүчтэй шилжих хандлага гарч байна. БХУЗХ нь БХҮБ, ДХБХС баримт бичгийн дэргэд бүс нутгийн хөгжлийн энэ шинэ хандлага, загварыг дэмжсэн хүрээг тогтоож өгч байгаагаараа чухал ач холбогдолтойг 3948 ТТ-ны баримт бичигт дурьдсан байгаа.

Өнөөгийн зохион байгуулалт, онолын асуудал нь голдуу төвлөрсөн бус аргыг тодорхойлсон байдаг. Энэ аргыг өргөн олноор хэрэглэх болсон хэд хэдэн үндэслүүд байдаг байх, Коста, бусад (1998, хх.5-6.) үүнээс хоёрыг нь чухалчлан тодорхойлсон байна. Нэгдүгээрт, хөрөнгийн глобалчлал ихсэж байгаа болон “дэлхий нийтийн буюу глобал эдийн засгийн бодит байдалд аль болох нийцэх, зөрчилдөөнийг багасгахад чиглэсэн үндэсний хөгжлийн бодлогын чадавхийг нэмэгдүүлэх дэлхий нийтийн буюу глобал зах зээл гарч ирж байна.”

“Дотоодын эдийн засгийн бодит байдалтай мөн зөрчилдөж байгаа эдийн засгийн бодлого” гэж энд нэмж тодотгомоор байна. Дэлхий нийтийн буюу глобал бодит байдал гэдэгт Дэлхийн Худалдааны Байгууллагын дүрэм, журмын дагуу хэрэгжиж буй олон арга хэмжээнүүд орно. Олон улсын эдгээр арга хэмжээнүүд нь тодорхой зарим салбарт дэмжлэг үзүүлэх, худалдааны татаас өгөхийг хязгаарлан микро эдийн засгийн бодлогын хүрээг хязгаарлах зорилготой байдаг. Төсвийн хүнд байдал нь өнөөгийн Монгол улсын бодит нөхцөл юм. ТТ-ны баримт бичигт дурьдснаар, “БХҮБ нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих Засгийн газрын өнөөгийн мэдэгдэл хэдий ч зах зээлд чиглэсэн, хөгжлийн эдийн засаг, санхүүгийн бодит нөхцөл байдалд маш няхуур хийсэн дүн шинжилгээнд тулгуулах шаардлагтай”.

Коста, бусад тодорхойлсон хоёр дахь хүчин зүйл нь “төв байгууллагын хүнд сурталтны хүлцэнгүй байдалд бүх нийтээр илэрхийлдэг дургүйцэлтэй холбоотой юм”. Хөгжиж буй улс оронд улс төрийн төвлөрлийг сааруулах хандлага нилээд ихэсч байгаа нь эдгээр улс оронд төрийн төв байгууллагуудын “уян хатан бус, идэвхгүй, үр ашиггүй, ихэнх тохиолдолд хээл хахуульд автагдсан” байдагтай нь холбоотой юм гэж Кингслэй-ийн (1996, х.419) хэлсэн үгийг тэд иш татаж байна.

Дүгнэхэд, “доороос дээш” чиглэсэн аргыг төлөвлөлтөд хэрэгжүүлэх хандлагыг бүх нийтээрээ өнөөдөр хүлээн зөвшөөрч байгаа энэ үед орон нутаг өөрийн тулгамдсан асуудлыг өөрсдөө шийдвэрлэхэд чиглэсэн орон нутгийн өөрийн бодлого, байр суурь нилээд хүчтэй байх шаардлагатай. БХУЗХ энэ хандлагад нийцэж байгааг өмнө дурьдаж байсан бөгөөд ТБУСХ, ДХТХ-ийн хүрээнд нийцүүлэн хэрэгжүүлэх боломжууд нилээд бий. Харин БХҮБ, БХДХС хоёр нь МОН 3948 ТТ хэрэгжих хугацаанд олон дахин илэрхийлж байснаар энэхүү хандлагад нийцэхгүй байгаа бөгөөд дараах зөвлөмжийг санал болгож байна:

- ➔ Зах зээлийн эдийн засгийн зарчим, Засгийн газрын хүлээх үндсэн үүргийг харгалзан БХҮБ, БХДХС-ийг дахин авч үзэх, шинэчлэх;
- ➔ Холбогдох олон талуудыг хамруулсан “”доороос дээш” чиглэсэн аргыг бүс нутгийн бодлогыг хөгжүүлэх, төлөвлөлтийг хийхэд хэрэглэх.

1.3 Хотжилт

Хөгжиж буй, хөгжингүй олон орнуудын нэгэн адил хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн ихсэх, хотжилт тэлж нэмэгдэх асуудлууд Монгол оронд тулгамдаж байна. Коста, бусад тэмдэглэж байгаагаар, дэлхийн хүн амын 29,3 хувь нь 1950 онд хот, суурин газарт амьдарч байсан бол 1995 онд 45,3 хувь болжээ. НҮБ-ын хэтийн тооцоогоор энэ үзүүлэлт 2025 онд 61,6 хувьд хүрэх юм байна.

Монголын бүс нутгийн хөгжлийн зорилгыг тодорхойлохдоо “хүн амын төвлөрлийг багасгахад чиглүүлэх” гэсэн байдаг. “Олон улсын туршлагаас харахад энэ зорилгыг хэрэгжүүлэх магадлал маш бага байна. Нилээд хатуу, төвлөрсөн хяналттай хүн амын бодлогыг хэрэгжүүлж байгаа Хятад улсад гэхэд хүн амын хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн их хэмжээгээр нэмэгдэж, бүртгэлгүй шилжин ирэгсдэд боловсрол, бусад

үйлчилгээг үзүүлэхэд хязгаарлалт хийх тухай асуудлыг Засгийн газар нь өнөөдөр авч үзэж байна.

Тэгэхлээр дээрх зорилтыг тодорхойлохдоо энэ шилжих хөдөлгөөн нь байх ч болно, цаашид үргэлжлэх хандлага ч их байгааг харгалзаагүй бололтой. Үүний зэрэгцээ орон сууцны чанар, хангамж муу, ахуйн ариун цэвэр муу, ихэнх шилжин ирэгсэд хотын нийтийн үйлчилгээг хүртэх боломж муу зэрэг олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогын зохистой хүрээг Монголд хэрэгжиж байгаа ядуурлыг бууруулах олон арван арга хэмжээнүүд тодорхойлж байна. Бүсийн төвүүдэд тулгарч байгаа эдгээр олон асуудлын заримыг нь шийдвэрлэхэд АХБ-ны хүрээнд хэрэгжиж буй хотын орон сууцны зарим төслүүд хувь нэмрээ оруулах юм.

1.4 Тогтвортой оршин тогтох

Хот, бүс нутгийн төлөвлөлтийн зорилтыг олон улсад хүлээн зөвшөөрч байгаагаар “тогтвортой оршин тогтох зарчимд нийцүүлэх явдал” юм. Тогтвортой оршин тогтнохыг дараах байдлаар ерөнхийд тодорхойлдог:

“Тогтвортой оршин тогтох нь тодорхой эдийн засгийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ өнөөгийн болон хойч үеийнхээ аль алины хэрэгцээ шаардлагыг хангасан байхыг шаардана”.

Тогтвортой оршин тогтох нь хүн амын үйл ажиллагааны удирдлагатай холбоотой бөгөөд тодорхойлолтод тусгаснаар хоёр асуудлыг хөндөж байна. Нэгдүгээрт, нийгмийн аль ч бүлэг, хэсэг хоорондын ялгааг багасгахад чиглэсэн хөгжлийг дэмжих юм (заримдаа үүнийг “үе хоорондын тэгш шударга байдал” (‘intra-generational equity’) гэж нэрлэдэг”). Энэ нь ихэнх улс орны бүс нутгийн хөгжлийн зорилготой нийцэж байгаа бөгөөд үйлчилгээ хүртэх, хөдөлмөр эрхлэх боломж, эдийн засгийн үйл ажиллагаа зэрэг асуудлаар хөдөөгийн болон хотын хүн амын ялгааг багасгах гэсэн бодлоготой бөгөөд Монгол орны хувьд ч мөн нийцэж байна.

Хойч үеийнхээ хэрэгцээ шаардлагыг бодолцох үүднээс, “дэлхий ертөнцийг дэмжих тогтолцоонд хохирол учруулахгүй байх”, өөрөөр хэлбэл дараах үеэ эрсдэлд оруулахгүй байх гэсэн зорилгыг санаа нэгтэй хүлээн зөвшөөрсөн (НҮБ, 1996, х.421.).

Тогтвортой оршин тогтох нь урт хугацааны хөгжлийн асуудал бөгөөд тогтвортой хөгжлийн нөхцөл шаардлагыг хангасан, эдийн засгийн

өсөлтөд чиглэсэн нийгэм, эдийн засгийн суурь институцийг бий болгох асуудлууд мөн үүнд хамрагддаг. Тогтвортой хөгжил нь дараах чухал хоёр асуудлыг харгалздаг:

- Эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудал буюу “тулгын гурван чулуу”;
- Үйл ажиллагааг бүрэн зохицуулах “Нэгдсэн засгийн газрын үйл ажиллагаа”-ны аргыг хэрэглэх.

Товч дурьдахад “тулгын гурван чулуу” нь 1-рт, хот болон бүс нутгийн төлөвлөлтөд эдийн засаг, нийгэм, байгаль орчны гурван асуудлыг харгалзах; 2-рт, эдийн засаг, нийгэм, байгаль орчны зэрэг гурван асуудлын тэнцвэрт харьцааг тогтоох; 3-рт, төлөвлөлт, хөгжилд орон нутгийн мэдлэг, эрх ашгийг тусгах үүднээс “доороос дээш” чиглэсэн аргыг төлөвлөлтөд хэрэглэх.

Хот болон бүс нутагт төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд олон үүрэг функцтэй засгийн газрын байгууллагууд үйл ажиллагааг явуулах, эдгээр нь орон нутгийн хүн амд, хамт олны хэрэгцээг дээд зэргээр хангах үйлчилгээг үзүүлэхдээ хоорондоо маш сайн зөвшилцөж байхыг “Нэгдсэн засгийн газрын үйл ажиллагааны арга” гэж нэрлэдэг. Эцсийн дүнд Засгийн газрын бүх байгууллагууд өөр хоорондоо нягт уялдаатай, байнга зөвшилцөх хэлбэрээр ажлаа явуулснаар төлөвлөгөөг сайн боловсруулж, хөгжлийн хамгийн сайн үр дүнд хүрэх юм.

2. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ

2.1 Зэх зээлийн эдийн засгийн тодорхойлолт

Зах зээлийн эдийн засгийн тодорхойлолт нь Засгийн газар ямар үүрэгтэй вэ гэдгийг тодорхойлоход нилээд мэдээллийг өгдөг. Рутерфорд (2002, х.349) дараах байдлаар зах зээлийн эдийн засгийг тодорхойлж байна:

“Засгийн газрын интервенци хийгээгүй нөхцөлд бараа, үйлчилгээ үнийн механизмаар хуваарилагддаг, их хэмжээний хувийн хэвшлийн хөрөнгөтэй эдийн засгийг нэрэлнэ. ... Зах зээлийн эдийн засаг хөгжин цэцэглэхэд **өрсөлдөх зах зээл** дээр ховор олдцыг нь үнээр илэрхийлсэн бараа, бүтээгдэхүүнтэй, бизнесийн хөгжлийг ашиг сонирхол урамшуулдаг байх ёстой”.

Энэ тодорхойлолтоос харахад, Засгийн газар хувийн салбарын зах зээлд оролцохгүй байх, бизнесийн шийдвэрийг харьцангуй давуу тал л тодорхойлох, ханган нийлүүлэлт, эрэлт хэрэгцээ хоорондын харьцаагаар илэрхийлэгдэх ховор олоц нь үнийг тодорхойлох гол хүчин зүйл юм.

2.2 Зах зээлийн алдаа

Өмнөх цуврал баримт бичгүүдэд дурьдаж байсанчлан зах зээл нөөц хөрөнгийг онвчтой төгс байнга хуваарилаад байдаггүй. Энэ байдлыг зах зээлийн алдаа хэмээн нэрлэдэг бөгөөд зах зээлд гаж буруу нөлөө үзүүлдэг. Дараах тохиолдолд зах зээл алдаа гаргадаг:

- Зах зээлд монополист нийлүүлэгч давамгайлах, өөрөөр хэлбэл зах зээлийн үнэ, нийлүүлэлтийг ганцаараа хянаж байдаг нэг л нийлүүлэгч юм. Олигополи байвал мөн адил, энэ нь цөөн хэдэн нийлүүлэгч үнэ, нийлүүлэлт дээр хамтраад хяналт тогтоодог, жишээ нь Нефть экспортлогч орнуудын байгууллага (ОPEC) шиг картель хамтран үнэ, нийлүүлэлтэд хяналт тавих;
- Тодорхой зарим бүтээгдэхүүний хэрэглээнээс улбаатай гаж нөлөө (externalities): гуравдагч талд санаатайгаар бус нөлөөлж, үүнийхээ төлөө төлбөр төлдөггүй;

- Зах зээл ховор, нийгмийн бараа үйлчилгээтэй адил тохиолдол;
- Хангалттай хэмжээний үйлчилгээг зах зах нийлүүлж чадахгүй, жишээлбэл боловсролын үйлчилгээ.

Зах зээл алдаа гаргах нь Засгийн газар ямар нэгэн хэлбэрээр интервенци хийхийг шаардана. Монополи нийлүүлэгч жишээлбэл зах зээлд ноёрхож байхад олон улс оронд өрсөлдөөнийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Харилцаа холбоо, эрчим хүч нийлүүлэх үйлчилгээг өмнө нь Засгийн газар үзүүлдэг байсан бол эдгээрийг хувьчилж, өрсөлдөөнийг дэмжих бодлого хэрэгжүүлэхийн хамт гадаад, дотоодын хувийн нийлүүлэгчдийг зах зээлд орох боломжийг нээж өгч энэ зах зээлийн алдааг залруулж байсан.

Аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн бохирдлыг гол ус, агаар мандалд хаях зэрэг бохирдолтой ихэвчлэн холбоотой гаж нөлөө² гардаг. Бохирдлыг ус руу хаяж байгаа бол урсгалын доод хэсэгт амьдарч буй хүмүүст, агаар мандалд хаях эсвэл их хэмжээний дуу шуугиан гаргах нь үйлдвэр орчмын оршин суугчдад нөлөөлнө. Бохирдуулж байгаа нэгж нь цэвэр агаар, цэвэр усыг үнэ төлбөргүй хэрэглэдэг учир энэ үнэгүй нөөцийг хямгатай ашиглах сонирхол байдаггүйтэй энэ байдал шууд холбоотой юм. Үйлдвэрлэлд маш хэрэгцээтэй ч үнэгүй учир олдоц хязгааргүй (ховор олдцыг тооцоогүй) энэ бүтээгдэхүүн нь зах зээл уналтанд орох нэг нөхцөл болдог. Энэ тохиолдолд эдгээр гаж нөлөөг залруулах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагаатай болдог, үүнд зохицуулах тодорхой хууль, тогтоомж, голдуу багц хууль, тогтоомжийг гаргаж, эдгээр нөөцийн зах зээлийг бий болгох, үнийг тогтоох зэрэг арга хэмжээнүүдийг авдаг. Нийгмийн бүтээгдэхүүн нь тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй хүн бүр хүртэх бүтээгдэхүүн байдаг бөгөөд төлбөр төлөөгүйгээс нэг нь энэ бүтээгдэхүүнийг хүртэхгүй байх, эсвэл нэг хүн хэрэглэснээр нөгөө хүний хэрэглээ багасах гэсэн ойлголт байдаггүй. Эдгээрт үндэсний аюулгүйн байдал, гудамжны гэрэлтүүлэг, хорио цээрийн үйлчилгээ г.м. ордог. Засгийн газар голдуу татварын орлогоос эдгээр үйлчилгээг санхүүжүүлдэг.

Алс хол газар нутагт тодорхой зарим үйлчилгээг зах зээл нийлүүлдэггүй. Эдгээр газарт шаардлагатай эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг зах зээл нийлүүлэхгүй, иймээс нийгмийн тэгш шударга байдлыг хангах зорилгоор эдгээр үйлчилгээг төр хариуцдаг.

² Externalities are defined in Policy Advisory Paper No. 2: *Important Concepts and Definitions for Regional Development Policy and Planning*.

Монголын ядуурлыг бууруулах хөгжлийн бодлого, төлөвлөлт нь зах зээлийн алдааг харгалзах чухал ач холбогдлыг тодотгон харуулж байна. Монголын хүн амын гуравны нэг нь ядуурлын түвшингээс доогуур амьдарч байна. Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн наад захын суурь үйлчилгээг нилээд их хүн хүртэж чадахгүй байна. Эдгээр үйлчилгээг бүх хүн амдаа тэгш шударга хүртээх зорилгоор энэ зах зээлийн алдааг залруулах гол үүргийг Засгийн газар хариуцдаг.

2.3 Өрсөлдөх давуу тал

Эдийн засгийн хөгжлийн амжилтанд хүрэх нэг гол нөхцөл нь бүс нутгуудад өрсөлдөх давуу талыг бүрдүүлэх явдал юм. Тодорхой өөрийн хөрөнгөтэй, бусад бололцоо боломжоо (үйлдвэрийн өртөг бага, түүхий эдийг эзэмших, зах зээлд хялбар хүрэх г.м.) зөв ашиглан өрсөлдөгч нийлүүлэгчээсээ өрсөлдөх давуу талтай байгаа байдлыг өрсөлдөх давуу тал гэж хэлнэ. Глобал зах зээлд өрсөлдөх давуу талыг олгож чадахуйц газар, бүс нутаг руу үйлдвэрлэл шилжин нүүх хандлагатайг судалгаа харуулж байна.

Энэ нь өртгийг бууруулах, нөөцийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэхэд өрсөлдөөний үүрэг ролийг тодотгон харуулж байгаа зах зээлийн эдийн засгийн тогтолцооны суурь юм. Гэвч өрсөлдөх давуу талыг зохиомлоор бүтээж болдоггүйг анхаарах нь чухал, хэрэв үүнийг хийвэл маш өндөр өртөгтэй болох бөгөөд эрсдэл ихтэй байна. Хувийн салбар алдаа гаргахтай холбогдсон эрсдлийг өөрөө хүлээж өрсөлдөх давуу талыг илрүүлдэг. Өрсөлдөх давуу талыг илрүүлэхэд Засгийн газар огт оролцдоггүй, эсвэл маш бага оролцоно.

Энэ нь БХҮБ, ялангуяа БХДХС-ийн том алдаа юм. Ямар салбар ямар байршилд хөгжихийг эдгээр баримт бичгүүдэд зааварчлан заасан байхад эдгээрийг угтаа хувийн салбар тодорхойлох юм. Засгийн газар нь ямар салбар ямар байршилд “хамгийн сайн” хөгжихийг тодорхойлж, түүнд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийгээд өгвөл, хувийн салбар тийш шилжин нүүх сонирхолгүй байх бөгөөд харин өрсөлдөх давуу талын бүх хүчин тогтолцоо бүрдсэний дараа л шилжих юм. Эдгээр хүчин зүйлийн тогтолцоо нь зах зээлийн түүхий эд нийлүүлэгчдийн хоорондын хоршилт, нэг нь нөгөөгөө нөхөх байдал, тухайн үйлдвэрлэлийн кластерийн нөлөөлөл, баталгаат зах зээлд хялбар хүрэх зэрэг юм.

3. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ БҮС НУТГИЙН ХӨГЖИЛД

3.1 Засгийн газрын ерөнхий үүрэг

Бүс нутгийн хөгжлийг хэрэгжүүлж байгаагаас үл хамааран Засгийн газар ерөнхий үүргийг хүлээдэг. Эдгээр нь:

- хууль, тогтоомж, үндэсний аюулгүйн байдал;
- Хөдөлмөр, хөдөлмөр хамгаалал ба хөдөлмөрийн эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зэрэг салбарын холбогдох дүрэм, журам ;
- Батлан хамгаалах, зэвсэгт хүчин;
- Микро, макро эдийн засгийн бодлого зэрэг эдийн засгийн бодлого, удирдлага;
- Татварын бодлого, хэрэгжилт, удирдлага;
- Олон улсад хүлээх үүрэг, гэрээ, хэлэлцээр г.м.;
- Цагаачлал, гааль, хил хязгаарын хяналтын арга хэмжээ;
- Иргэдийн эрхийг хамгаалах;
- Шаардлагатай үед зах зээлийн алдааг залруулах.

Энэ нь бүрэн жагсаалт биш бөгөөд “нийгмийн үйлчилгээ” гэдэгт багтах үндсэн чиглэлүүдийг л тодорхойлсон. Эдгээр зарим үйлчилгээг Засгийн газар гаднах эх үүсвэрээр хийлгэж болдог. Жишээлбэл, цагаачлал, гаалийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн салбар хэрэгжүүлж болох юм. Эдгээр үйлчилгээг үзүүлэхэд Засгийн газар зохих бодлогыг нь боловсруулж, үйл ажиллагааны журмыг тогтооно.

3.2 Засгийн газрын үүрэг бүс нутгийн хөгжилд

3.2.1 Өсөлтөд чиглэсэн макро эдийн засгийн тогтолцоо

Монголын бүс нутгийн хөгжлийн бодлого нь микро эдийн засгийн бодлогод их хэмжээгээр тулгуурлж байгаа нь бүс нутгийн хөгжлийн арга хэмжээний хувьд ердийн байдал юм. Нийгмийн үйлчилгээ үзүүлэх нилээд чухал үүргийг Засгийн газар хүлээж, микро эдийн засгийн

бодлогуудыг маш сайн боловсруулсан ч макро эдийн засгийн тогтолцоо нь өсөлтийг дэмжих бус байвал эдгээрийн үр дүн бага, “захаас нь дөнгөж эмрэх” хэмжээнд байна гэсэн дүгнэлтийн Лэмонт (2003) хийжээ. Иймд, макро эдийн засгийн бодлого нь нэгдүгээрт анхаарах асуудал бөгөөд өсөлтийг дэмжих бус байвал микро эдийн засгийн бодлого нь олигтой үр дүнд хүрэхгүй. Нөгөөтэйгүүр микро эдийн засгийн бодлого нь макро эдийн засгийн бодлогод нөлөөлнө. Лэмонт (2003, х.2) хэлснээр:

“Засгийн газрын бүс нутгийн хөгжлийн талаарх сүүлийн үеийн баримт бичгүүдэд микро эдийн засгийн хөшүүргийг (татвар, гаалиас чөлөөлөх, чөлөөт эдийн засгийн болон тусгай бүс байгуулах, зээлийн хэлбэрийг нэвтрүүлэх г.м.) хэрэглэх талаар нилээд түлхүү анхаарч байна. Эдгээр нь нөгөөтэйгүүр макро эдийн засгийн байдалд нилээд нөлөөлж, ялангуяа бүс нутаг бүрт хэрэгжих гэж байгаа Монголын эдийн засгийн хувьд энэ нь бүр ч их нөлөөтэй юм.”

Өнөөгийн байдлаар Засгийн газрын хэрэгжүүлж буй макро эдийн засгийн болон санхүүгийн бодлого нь Ядуурлыг Бууруулах Өсөлтийг Дэмжих хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн үүргээр хязгаарлагдаж байгаа бөгөөд үүргийн дагуу өсөлтийг дэмжих бус харин тогтвортой байдлыг хангахад илүү анхаарсан бодлого юм. Энэ байдлаас гадна, эдийн засгийн бодлогыг таван бүс нутагт хуваах боломжгүй, өсөлтөд чиглэсэн үндэсний нэгдсэн чиг бодлого хэрэгтэй байна гэж мөн Лэмонт (2003) тэмдэглэжээ. Иймд бүс нутгийн хөгжлийн микро эдийн засгийн бодлогууд хэрэгжиж эхлэх, үр дүнгээ нилээд өгөхөөс нь өмнө үндэсний эдийн засгийн онвочтой суурь бодлого шаардлагатай байна.

Макро эдийн засгийн тогтолцоо, өнөөгийн байдал, өсөлт, бүс нутгийн хөгжил зэрэг асуудлаар Лэмонт (2003) нилээд дэлгэрэнгүй тайлбар хийсэн байна.

3.2.2 Таатай зохистой орчныг бүрдүүлэх

Эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэх, тэлэн өргөжүүлэх хөдөлгүүр нь хувийн хөрөнгийн зах зээл байдаг. Идэвхтэй хөрөнгийн зах зээлтэй орнуудад дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжтой. Хувийн хөрөнгийн зах зээл нь тухайн улс орны улс төрийн тогтолцоог урьдчилан харж болох, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт нь ил тод байх нөхцөлд л хөгжих боломжтой. Иймд, улс төрийн байдлыг урьдчилан харах боломжгүй, ил тод бус байдал нь тухайн улс үндэстэн хөрөнгийг өөртөө татахад гол саад хотгор болох гол хүчин зүйл юм (иймд урт хугацааны жишээлбэл уул уурхайн

хөрөнгө оруулагчид тухайн засгийн газартай "тогтвортой байдлын" гэрээ хийх сонирхолтой байдаг).

Монголын бүс нутгийн стратегид зохих хэмжээний хөрөнгө оруулалтыг зах зээлийн хүүгийн ханшаар хувийн салбарыг санхүүжүүлэхэд нийлүүлэх хандлага гарч байна. Зах зээлийн хүүгийн ханш их өндөр байгаа өнөөгийн мөнгөний бодлогын хүрээнд энэ арга хэмжээ хэрэгжих боломж муутай. Санхүүгийн салбарын хөгжлийг урт хугацаанд дэмжих шаардлагатай бөгөөд үүнийг бүс нутгийн хөгжил, эдийн засгийн хөгжлийг дэмжих хандивлагчдын эх үүсвэр бүхий үйл ажиллагаагаар хэрэгжүүлж болох юм.

Эдийн засгийг хөгжүүлэх, татварын бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн бодлого чухал бөгөөд бизнесийн хөрөнгө оруулалтыг татах орчин нөхцлийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй. Татварын хэмжээ бөгөөд татвар ногдуулалт Монголд харьцангуй их. Аж ахуйн нэгж, хувь хүний орлогын албан татварын дээд хэмжээ 40 хувь, НӨАТ нь 15 хувь байна. Энэ талаар Лэмонт (2003) дэлгэрэнгүй бичжээ.

Бизнесийн лиценз болон төрөл бүрийн зөвшөөрөл олгох, ажилчдын даатгал, өндөр настны тэтгэвэрийн сан зэрэг бизнесийн үйл ажиллагааг зохицуулах хууль, журам нь таатай орчныг бүрдүүлэх нөхцөл юм. Лиценз, зөвшөөрлийг олгох тогтолцоо нь ил тод, хууль журам нь тодорхой, ойлгомжтой, асуудлыг шийдвэрлэхэд бэлэн олдцтой байх зэрэг бизнесийн хөгжил, өсөлтийг нь шууд дэмжих чухал нөхцөл байдал юм.

Бүс нутгийн төлөвлөлт, хөгжилд тогтвортой байдлыг хангах нь чухал гэдгийг бүлэг 1-д хэлэлцсэн. Байгалийн баялаг, бусад нөөцийн эх үүсвэрийг тогтвортой хөгжилд чиглүүлэн зөв ашиглах хууль, тоогтоомжийг гаргахад Засгийн газар чухал үүрэгтэй. Бусад хууль, тоогтоомжийн адил эдгээр нь мөн ил тод, ойлгомжтой, тодорхой байх ёстой.

Бүс нутгийн хөгжлийн сүүлийн 20, 30 жилийн дэлхий нийтийн хандлагыг харахад арилжааны байгууллагад түүнээс ч их дэд бүтцэд засгийн газрын шууд хөрөнгө оруулалтыг хийхээс зайлсхийж байна. Засгийн газар шууд хөрөнгө оруулалт хийх бодлогоос татгалзаж харин ЖДҮ-ийн бага өртөгтэй бүтээгдэхүүн үйлчигээг бий болгохыг дэмжих, хөнгөвчлөх бодлого, стратегийг баримтлах, бизнесийн зөвлөлгөө өгөх, зах зээлийн мэдээллээр хангах, эрдэм шинжилгээний ажлаар дэмжих, санхүүгийн эх үүсвэр олоход туслах зэрэг үйлчилгээг үзүүлж байна.

3.2.3 Микрo эдийн засгийн бoдлого

Зах зээл дээр хэрэглэгч, нийлүүлэгч хоёр хэрхэн шийдвэр гаргаж, үнэ яаж тодорхойлогдож байгаатай микро эдийн засгийн бoдлого шууд уялдаатай. Түүнчлэн ховор нөөцийг зах зээл хуваарилж байгаатай мөн микро эдийн засгийн бoдлого холбоотой. Тухайн зах зээл буюу аж үйлдвэрийн салбарын тодорхой зорилтыг Засгийн газар микро эдийн засгийн бoдлогоор тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх бoдлогын хэрэглүүрийг ашигладаг. Нөөц хөрөнгийг үр ашигтай ашиглах, үүнд саад хотгор болж байгаа асуудалд гол нь анхаарах юм. Өрсөлдөх бoдлого, аж үйлдвэрийн бoдлого, бүс нутгийн хөгжлийг бoдлогууд нь микро эдийн засгийн бoдлогын жишээ юм.

Микро эдийн засгийн бoдлогыг боловсруулах гол үүрэг Засгийн газарт ногдох бөгөөд бүс нутагт хувийн салбар хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаагаа явуулах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой. Харамсалтай нь, микро эдийн засгийн бoдлогыг боловсруулах чадавхи өнөөгийн байдаар Засгийн газарт сул байна. Иймд, дараах зөвлөмжийг гаргаж байна:

- ➔ Эдийн засгийн бoдлого боловсруулах чадавхийг бүрдүүлэх, бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэг туслалцааг хандивлагчдаас авах, боломжийн тохиромжтой байршил нь СЭЗЯ-ны ЭЗБТГ юм.

3.2.4 Бүс нутгийн хөгжлийг дэмжих, хөнгөвчлөх

30-аад жилийн өмнө буюу Дэлхийн хоёрдугаар дайн дуусны дараа ихэнх улс орны бүс нутгийн хөгжлийн чиг хандлага нь засгийн газрын интервенцид тулгуурласан байв. Хоёр онцлогийг харгалзаж байсан, үүнд:

- Аж үйлдвэрийн уналт ажиглагдаж байгаа салбар болон ажилгүйдлийн түвшин өндөр байгаа зэрэг асуудалд илүү анхаарах ;
- Дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх, ихэнх тохиолдолд арилжааны үйл ажиллагаанд шууд хөрөнгө оруулалт хийх.

Эхний онцлогтой холбогдуулан дотогши чиглэсэн хөрөнгө оруулалтын бoдлогыг хэрэгжүүлэх нь түгээмэл байсан. Хоцрогдсон газар нутагт үйлдвэрлэл бий болгох, компани пүүсийг татснаар эдгээр газар нутгийн эдийн засгийг идэвхжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлнэ гэсэн тооцоотой бoдлого байв. Энэ хэлбэрийг “ажлын байрыг хүн

болгонд дөхүүлж өгөх” гэж нэрлэж байсан. Олон төрлийн арга хэлбэрийг хэрэглэсний дотор санхүүгийн (хөрөнгө оруулалтын тусламж, бага хүүтэй зээл, татвараас чөлөөлөх, г.м.) болон аж үйлдвэрийн зоончлолыг (тодорхой заасан талбайгаагаас гадагши байрлахгүй байх нөхцөлтэй) хэрэгжүүлж байсан.

Дотогш чиглэсэн хөрөнгө оруулалтын аргыг хэрэглэснээр гарсан үр дүн, амжилт нь хязгаарлагдмал байв. Хүн амын нягтрал ихтэй Нэгдсэн Вант Улс зэрэг бусад улс оронд аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангаж чадаагүй. Хөгжил сул бүс нутаг руу пүүс, компаниудыг татах таатай орчныг бүрдүүлэх өртөг, нэг ажлын байранд ногдуулан тооцноор ихэнх тохиолдолд өндөр гарч байв. Өрсөлдөх давуу тал байхгүй, кластер бий болоогүй байснаас эдгээр арга хэмжээ амжилттай хэрэгжиж чадаагүй. Анх хөгжүүлэх гэж байсан аж үйлдвэр амжилтанд хүрээгүй, эсвэл огт хөгжөөгүй байгааг нилээд сайн судлах, цаашид харгалзах шаардлагатай гэж Парр (2001) хэлсэн байдаг.

Мөн адил дотогши чиглэсэн хөрөнгө оруулалтын аргыг Канадад 1960, 1970-аад онуудад хэрэгжүүлсэн (Эдийн Засгийн Хүрээг Тэлэх Газрын удирдлага дор (ЭЗХТГ)). Робинсон, Томпсон (2003, х.15) нарын бичиж байгаагаар: “хоцрогдсон бүс нутагт аж үйлдвэрийг татан байршуулах эсвэл шинээр бий болгоход Засгийн газрын дэмжлэг туслалцаа чиглэж байв; бүс нутгийн ашиглагдаагүй нөөцийг ашиглахад мөн чиглэсэн байв. Түүнчлэн зогсонги байдалд орсон, хаагдах гэж байгаа үйл ажиллагааг мөн дэмжиж ирсэн”. Урт хугацаанд тогтвортой байдлыг хангах асуудлыг харгалзаагүй, зах зээлд өөрөө өөрийгөө аваад явч чадахгүй аж ахуйн нэгжүүдэд их хэмээний дэмжлэг, тэтгэлгийг засгийн газраас удаан хугацаанд өгч байсан гэж Робинстон, Томпсон нар тэмдэглэсэн байна. Бүс нутгийн хөгжлийн энэхүү аргыг цаашид хэрэглэх Засгийн газрын сонирхол 1980-аад онд ихэд буурсан.

“Ялагчийг тодорхойлох” аргыг (БХДХС-д нилээд онцлон хэрэглэсэн) Засгийн газар хэрэгжүүлэхийг оролдсон боловч энэ нь өндөр өртөг тэй алдаанд хүргэх эрсдэлтэй байсан гэж Робинстон, Томпсон нар цаашид тэмдэглэсэн байна. Тэдний дүгнэж байгаагаар, “хөрөнгийн их багтаамжтай төслүүдийг Засгийн газраас ихэд дэмжсэн боловч орон нутгийн хөгжил хүсэн хүлээгдэж байсан өсөлтийн түвшинд хүрээгүй юм”. Өөрөөр хэлбэл, хэрэгжсэн ихэнх төслүүд нь өндөр өртөгтэй, орон нутагт үр өгөөж өгөх нь цөөн хэд байсан бөгөөд харин урт хугацаанд нилээд ажлын байрыг бий болгосон юм.”

Дэд бүтцэд, ялангуяа тээврийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хий явдал бүс нутгийн хөгжлийн нийтлэг стратеги болж байсан, түүнчлэн БХҮБ, БХДХС-ийн ч мөн чухал хэсэг байгаа юм. Япон, Канад, Австрали зэрэг орны туршлагаас харахад энэ арга нь бүс нутгийг амжилттай хөгжүүлнэ гэсэн баталгаа болж чададгүй. Энэ аргын алдаа нь дотогши чиглэсэн хөрөнгө оруулалтын бодлого амжилтанд хүрээгүйтэй адил шалтгаантай юм.

Гэхдээ, дэд бүтцийг хөгжүүлэх асуудлаар Засгийн газар оролцох бололцоо боломж бий. Эдийн засгийн үр өгөөжөө өгнө гэсэн тодорхой бодит тооцоо, судалгаатай арга хэмжээг санхүүжүүлэх, өөрөөр хэлбэл “эрэлт хэрэгцээнд захирагдсан” байх нь маш чухал. Жишээлбэл, тодорхой хэмжээгээр үйл ажиллагаагаа эхэлсэн уурхайд дэмжлэг үзүүлж дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх нь татварын орлогоор, хөрөнгийн өртөг нөхөх гэрээгээр, хөдөлмөр эрхлэлт, зарим үйлчилгээ үзүүлсний төлөө авах төлбөр зэргээр эдийн засгийн үр өгөөж нь гарах юм. БХҮБ, БХДХС-ийн арга нь “ханган нийлүүлэх талыг барьсан” арга бөгөөд их хэмжээний дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх хандлага юм. Энэ бодлого нь өндөр өртөгтэй, бага үр өгөөж өгөх талвай байдаг.

Зам, эрчим хүч, харилцаа холбоо, усан хангамж г.м. бараг ихэнхи салбарын үйлчилгээг Засгийн газар үзүүлдэг байсан бол сүүлийн арав, хорин жилд хувийн салбарт шилжүүлэх хандлага нилээд гарсан. Бүс нутгийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөрөнгийг Засгийн газар зээлж авч байснаас дэд бүтцийг хөгжүүлэх хувийн салбарын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр дэмжих нь зүйтэй юм. Хувьчлалыг нилээд амжилттай хэрэгжүүлсэн Монгол орны хувьд энэ бодлогыг дэмжих, хүлээн зөвшөөрөх боломжтой.

Засгийн газрын хөрөнгө оруулалттай холбогдсон дараах зөвлөмжүүдийг гаргаж байна:

- ➔ Санал болгож байгаа тээврийн, ялангуяа замын хөрөнгө оруулалтын төсөлд эдийн засгийн үр ашгийн иж бүрэн тооцоог хийх:
- ➔ БХҮБ, БХДХС-д хэрэглэсэн “ханган нийлүүлэх талыг барьсан” аргын оронд “эрэлт хэрэгцээнд захирагдсан” дэд бүтцийн хөрөнгө оруулалтын бодлогыг Засгийн газар хэрэгжүүлэх.

3.2.5 Бодлого болон хөгжлийн үйл ажиллагааг зохицуулах

БХҮБ, БХДХС нь шууд зааварчлах хандлагатай байгааг 3948 ТТ-ны хүрээнд хийсэн ажлын явцад удаа дараа тэмдэглэж байсан. Түүнчлэн энэ аргаар Засгийн газар өрсөлдөх давуу талыг тодорхойлж, “ялагчийг сонгож”, ямар салбар ямар байршилд хөгжихийг заасан байна. Зах зээлийн эдийн засагт энэ арга бараг нөлөөгүй байдаг.

Макро эдийн засаг, санхүү, төсөв, бодлогын бусад тогтолцоог бий болгох, бизнесийн хөгжлийг дэмжих таатай орчныг бүрдүүлэхээс гадна бодлого, эдийн засгийн хөгжлийн үйл ажиллагааг зохицуулах үүргийг Засгийн газар хүлээдэг. Хоёр буюу олон талт хамтын ажиллагааны тусламжийг хүлээж авч байгаа Засгийн газрын хувьд бодлого, хөгжлийн үйл ажиллагааг зохицуулах ажлын ачаалал ихэд нэмэгдэж байгаагаар холбогдуулан энэ нь бүр ч чухал болох юм. Иймд дараах зөвлөмжүүдийг гаргаж байна:

- ➔ Бүс нутгийг хөгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар эдийн засгийн хөгжлийг дэмжих, хөнгөвчлөхөд чиглэсэн үндсэн үүрэгтээ голлон анхаарах нь чухал;
- ➔ Үндэсний Хороо, Бүсийн зөвлөлүүд, эдгээрийг дэмжих мэргэжлийн албууд нь бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааг зохицуулах үүргийг хүлээж, харин удирдан хэрэгжүүлэх үүргийг чиглэлийн яамд хариуцна;
- ➔ Бүс нутгийн хөгжил, бодлого, хэрэгжилтийг зохицуулах, Үндэсний Хороог дэмжих үүрэг бүхий, чадварлаг зохих бүрэлдэхүүнтэй мэргэжлийн албыг Хэрэг эрхлэх газарт байгуулах;
- ➔ Энэхүү мэргэжлийн албыг байгуулах, үйл ажиллагаанд нь АХБ-аас дэмжлэг тусалцаа үзүүлэх;
- ➔ Дэмжлэг тусалцааг үзүүлэх чиглэл, байршлын талаар энэхүү ТТ-аас гарсан дүгнэлт зөвлөмжийг үндэслэн бүс нутгийг хөгжүүлэх дэмжлэг тусалцааг АХБ цаашид чиглүүлэх.

НОМ ЗҮЙ

Коста, Ф.Ж., Нобель, А.Г., Дуут А.К., Кент, Р.Б “21-р зууны Бүс нутгийн хөгжил ба төлөвлөлт.” [хх. 1-18. Ашгат, Алдершот, НВУ.] номны Коста, Ф.Ж., Нобель, А.Г., Кент, Р.Б ба Ашок, К.Д., 1998. “Өнөөгийн өөрчлөлт, шинэчлэл: Хот төлөвлөлт ба бүс нутгийн хөгжил”.

Кингслей, Ж.Т. 1996. “” Kingsley, G.T. 1996. “Шилжүүлэхийн цаашдын ирээдүйн хандлага”. Америкийн төлөвлөлтийн холбооны сэтгүүл. 45(4), хх.419-426.

Лэмонт, Ж. 2003. “Бүс нутгийн хөгжлийг дэмжих эдийн засгийн бодлогын хүрээ” Хэлэлцүүлгийн баримт бичиг № 2, “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ. Улаанбаатар. 2003 оны 8-р сар.

Робинсон, Т.Р. ба Томпсон, Д. 2003. “Орон нутгийн засаг захиргаа ба өөрчлөн шинэчлэлт: Харилцаа холбоо, шаардлага, тулгамдсан асуудлууд” “Гадаад орнуудын туршлагаас Монгол сургамж авах нь”. АХБ-аас Засгийн газарт гаргаж өгсөн баримт бичиг.

Рутерфорд, Д. 2002. *Роутледж, Эдийн засгийн толь бичиг*. Роутледж Хэвлэх газар. Лондон, Нью-Йорк.

НҮБ. 1995. *Дэлхийн хотжилтын төслүүд*. НҮБ, Нью-Йорк.